



2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/121

Зуураг

Газар эзэмших эрхийг баталгаажуулж,
газрын хэмжээг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37.1, 37.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р баг, Соёл хотхон, Цэцээ гүний гудамж 103 тоот хаягт байрлах Монгол туургатан театрын барилга барих зориулалтаар эзэмшиж буй 9573 м² газрын хэмжээг одоогийн байгаа хэмжээгээр буюу 7972 м² болгон өөрчилж Монгол туургатан театр /9061177/-т урлаг, соёлын байгууллагын зориулалтаар 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Монгол туургатан театр /Д.Мөнхбат/-т дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.


2.2. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.3. Холбогдох хууль тогтоомж, хэсэгчилсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/467 дугаар захирамж болон газар эзэмших эрхийн 000441401 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 000215